

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ  
ХУВЬЦААТ КОМПАНИ

**ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын нэр: **110/35/10 кВ-ын Бэрх дэд станцын тоноглолуудын  
төмөр бетон суурь нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон  
шалгаруулах тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **Т-ХА№19/09**

**Хаяг:** Улаанбаатар хот Багануур дүүрэг  
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”  
ТӨХК-ийн конторын байр.

**Утас:** 99020551, 99665151  
**Факс:** 70210167

**Нэг. Т-ХА№19/09** тоот тендерийн үнийн санал авах урилга

**БЗӨБЦТС ТӨХК нь 110/35/10 кВ-ын Бэрх дэд станцын тоноглолуудын төмөр бетон суурь** нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. /Тендерийн баримт бичгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу/

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хаяг:** Улаанбаатар хот, Багануур дүүрэг, үйлдвэрийн хэсэг, “БЗӨБЦТС” ТӨХК-ийн конторын байр 202 тоот өрөө.

**Утас:** 99665151, 99020551

**Факс:** 70210167

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, цахим системээр нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон ийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Техникийн тодорхойлолт.<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал. /ТШӨХ-ийн ТООЗ 1.1-д заасны дагуу/  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.  |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Үнийн саналын маягтын дагуу үнийн санал ирүүлнэ.</li> <li>2. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар. НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан бичиг ирүүлнэ.</li> <li>3. Барилга угсралтын тусгай зөвшөөрлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний хамт ирүүлнэ.</li> <li>4. 2018 оны нийт борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дах заалтын дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/.</li> <li>5. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолт, зураг ирүүлнэ. /Захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байх/</li> <li>6. Тендерийн баримт бичгийг цахимаар авна.</li> <li>7. Гэрээний тусгай нөхцлийн 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ.</li> <li>8. Чанарын баталгаат засварын хугацааг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ.</li> <li>9. Бараа материал нийлүүлэх хугацаа хуанлийн 5 хоногоос ихгүй байна.</li> <li>10. Ижил төрлийн гэрээ гүйцэтгэж байгаа нь тендерээс татгалзах үндэслэл болно.</li> <li>11. Сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, гэрээний үүргээ бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ. /Ижил төстэй ажилд бетон цутгамал суурийн ажил хийж гүйцэтгэсэн туршлагатай байна./ Захиалагчийн тодорхойлолт ирүүлээгүй тохиолдолд гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан гэж үзэн уг тендерээс татгалзана.</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:  <b>УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн байр, 2-р давхар 202 тоот өрөө Утас:99665151</b></p>
ТӨӨЗ 2.1	<p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b> Энэхүү бараа материал нийлүүлэх тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хаягаар орж дэлгэрэнгүй мэдээллийг авч тендерийг цахимаар илгээнэ үү.  Тендер хүлээн авах эцсийн хугацаа: <b>2019 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 09 цаг 00 минут.</b></p>
ТӨӨЗ 2.2	<p><b>Тендерийн нээлт хийх хугацаа нь:</b>  Цахим тендерийн нээлтийг <b>2019 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 09 цаг 30 минутад</b> цахим системээр нээнэ.</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлалгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тухайн аж ахуйн нэгж шүүхийн ямар нэгэн маргаанд хариуцагчаар оролцож байгаагүй тухай шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт.</li> <li>2. ШШГЕГ-ын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт. /Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байх/</li> <li>3. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх. /Татварын тодорхойлолтыг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим сайтын лавлагааг үндэслэнэ/</li> <li>4. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар.</li> </ol> <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтын шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b></p>

Дөрөв. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Барааны тодорхойлолт:**
2. **Стандарт:**
3. **Бараа хүргэх газар:** Хэнтий аймаг Бэрх тосгон ажлын талбайд.
4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмж их нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
<b>110/35/10 кВ-ын Бэрх дэд станцын тоноглолуудын төмөр бетон суурь</b>				Хэнтий аймаг Бэрх тосгон ажлын талбайд.	3 хоног	5 хоног	


**110/35/10кВ Бэрх дэд станцын 110 кВ-ын тоноглолын төмөр бетон суурийн тоо  
ХЭМЖЭЭ**

Д/д	Нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Задаргаа
1	<b>110 кВ-ын тоноглолын хүчитгэсэн төмөр бетон суурь /ажлын зургаар/</b>	ш	28	<ul style="list-style-type: none"> <li>• <b>110 кВ-ын хийт таслуурын суурь /4 ширхэг/ Боолт-16ш /M24/ Гайк-64ш Шайба-32ш</b></li> <li>• <b>110 кВ-ын гүйдлийн трансформаторын суурь /4 ширхэг/ Боолт-16ш /M24 марктай/ Гайк-64ш Шайба-32ш</b></li> <li>• <b>110 кВ-ын хүчдлийн трансформаторын суурь /2 ширхэг/ Боолт-8ш /M24 марктай/ Гайк-32ш Шайба-16ш</b></li> <li>• <b>110 кВ-ын хуурай салгуурын суурь /10 ширхэг/ Боолт-40ш /M24 марктай/ Гайк-160ш Шайба-80ш</b></li> <li>• <b>110 кВ-ын цэнэг шавхагчийн суурь /6 ширхэг/ Боолт-24ш /M24 марктай/ Гайк-96ш Шайба-48ш</b></li> <li>• <b>110 кВ трансформаторын саармаг цэгийн газардуулагчийн суурь /2 ширхэг/ Боолт-8ш /M24 марктай/ Гайк-32ш Шайба-16ш</b></li> </ul>

**Техникийн тодорхойлолт**

- Бетон цутгамал аяган суур нь ажлын зургийн дагуу M24 анкер боолт байрлуулсан  $V=1.636\text{м}^3$  эзэлхүүнтэй БМ-300 буюу /B25/ марктай бетон цутгамал аяган суурь байх ба гадар нь хар тосон түрхлэгтэй байна. /Зураг хавсаргав/
- Бетон цутгамал аяган суурийн хэмжээ: 1550\*1550\*400 мм суурь, 750\*750\*1500мм хүзүү хэсгээс бүрдсэн аяган суурь байна.
- Ган хавтангийн хэмжээ 8\*550\*550мм хэмжээтэй байна.
- Боолт /M24/ марктай 1000мм-ын урттай үзүүр дээрээ 150мм хэмжээтэй тахир дэгээтэй байна. /Зураг хавсаргав/
- Гайк M24 ГОСТ 5915-70 марктай байна.
- Шайба 24 ГОСТ 11371-78 марктай байна.
- Бүх суурийн дор /B7.5/ марктай 1750\*1750\*100мм хэмжээтэй бетон дэвсгэр байна.

# Ажлын зураг



**Тайлбар.**  
 1. Төмөр бетон суурийн хөрстэй харьцах гадаргуу хар тосон түрхлэг 2 дахин хийнэ.  
 2. Буцааж дарах хөрс 1.7 г/см<sup>3</sup> нягттай байх ба чийглэгийг шалааж, БНДЭЗ.02.0190-8 заасны дагуу буцааж барна. Буцааж дарах хөрс ургамлын үртэй, органик хольцтой, хүлэр, ширхэгтэй хөрс, обойлт, суулт үүсгэдэг хөрс байж болохгүй.  
 3. Боллны зэрэг 5.8 (ГОСТ 1795.4-87/ ISO 898 /1)

Д/А	Тэмдэглэгээ	Нэр	Тоо	Нэгж жин, кг	Нийт жин, кг	Тайлбар	
1	1000	M24	L1000	4	6	24	
2	1450	φ16 SD390 MNS JIS G 3112:2002	L=1600	8	2,96	23.68	
3	φ8	AI	ГОСТ5781-82	L=2760	8	1,09	8.72 α=200
4	φ8	AI	ГОСТ5781-82	L=1800	4	0,71	2.84 α=200
5	-8x550		L=550	1	19,00	19.00	
6	Тор Т-1	φ13 SD390 MNS JIS G 3112:2002	L=1500	20	1,49	29.80 α=150	
7		Гайнд M24	ГОСТ 5915-70	16	0,22	3.52	
8		Шайба 24	ГОСТ 11371-78*	8	0,04	0.32	
9		Шайба -12x90x90		4	0,76	3.04	
10		Бетон анги B25		-	V=1,636м <sup>3</sup>	V=1,636м <sup>3</sup>	
11		Бетон бэлгэл B7.5		-	V=0,31м <sup>3</sup>	V=0,31м <sup>3</sup>	

REV	DATE	REVISION DESCRIPTION	DESIGNED BY	REV	DATE	REVISION DESCRIPTION	CHECKED BY	REFERENCE DRAWINGS	REFERENCE DRAWING No.
00	00/00/00	ISSUED FOR CONSTRUCTION							

ХЭНТИЙ АЙМАГ, БЭРХ СҮМ, 110/35/10 кВ-ЫН 16 МВА ЧАДАЛТАЙ "БЭРХ" ДЭД СТАНЦ

Трансформаторын саарнаг цэврийн газардуулагчийн суурь

Шифр: BS1833-03S-6

ХТ

МАСШТАБ: 1:1

00 11 1

2018

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

2019 оны .... дүгээр сарын .....-ны өдөр

**БЗӨБЦТС ТӨХК**-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших  
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт  
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх  
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх  
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа  
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог чанарын баталгаат хугацаа **1 /нэг/** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах  
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр  
7.1. Захиалагч төлбөрийг **2019 оны 12-р сарын 25-ны дотор** төлнө.
8. Бараа нийлүүлэх хуваарь  
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах  
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах  
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх  
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
  - 1.1. Захиалагч бараа материалыг ажлын хэсэг томилон шалгаж үзнэ. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн бараа материалыг хүлээн авна.
  
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
  - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
    - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
    - 2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
  
3. Баталгаат засвар (ГЕН-5)
  - 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
    - 5.1.1. Захиалагч чанарын баталгааны хугацаанд гэрээний үнийн дүнгийн 5%-тай тэнцэх мөнгийг өөрийн дансанд байршуулна.
  
4. Төлбөр (ГЕН – 7)
  - 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
    - 7.1.1. Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн **2019 оны 12-р сарын 25-ны дотор** төлнө.
  
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>
  - 9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн **0,5%**.

Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **10%-с** ихгүй байна.

